

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЛБАРТ  
2022-2025 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ  
БҮГД НАЙРАМДАХ ИТАЛИ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,  
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХӨТӨЛБӨР**

Бүгд Найрамдах Итали Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар (Цаашид “Талууд” гэх)

- Бүгд Найрамдах Итали Улс, Монгол Улс хооронд 1973 оны 2 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан соёлын талаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийн 7 дугаар зүйлд заасны дагуу;
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэхийг эрмэлзэн;
- Хамтран ажиллах тухай хөтөлбөрийг 2022-2025 он болгон сунгахаар тохиролцов.

**1 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

**БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА**

**Бага болон дунд боловсрол**

- 1.1 Талууд өөрсдийн санхүүгийн бололцоонд тулгуурлан бага дунд сургууль болон тэдгээрийн удирдлагын хооронд, ном, сургалтын бусад материал солилцох чиглэлээр нягт хамтын ажиллагааг дэмжинэ.
- 1.2 Талууд боловсрол, сургалтын чиглэлээр санаачилга гаргахыг дэмжих бөгөөд түүнийг хэрэгжүүлэхийг чармайна. Дэлгэрэнгүй болон санхүүжилтийн заалтыг дипломат шугамаар харилцан тодорхойлно.

**Дээд боловсрол**

- 1.3 Талууд Итали, Монголын их сургууль, дээд боловсролын байгууллага, түүний дотор урлаг, хөгжим, спортын байгууллага хооронд шууд хамтын ажиллагааны гэрээ болон конвенц байгуулах, багш болон мэдээ мэдээлэл солилцох, түүнчлэн хурал, семинар, хамтран зохион байгуулах, судалгаа, шинжилгээний төсөл хэрэгжүүлэх зэргээр хамтран ажиллахыг дэмжинэ.
- 1.4 Талууд жил бүр их, дээд сургуулийн хоёр багш, эсхүл судлаачийг найман (8) хоног хүртэлх хугацаагаар харилцан солилцох бөгөөд хоёр улсын их, дээд сургууль, дээд боловсролын бусад байгууллага хоорондын шууд хамтын ажиллагааг дэмжих зорилгоор нийтлэг сонирхолтой судалгааны салбарыг тодорхойлж хамтран ажиллана.

- 1.5 Цаашид Талууд их, дээд сургуулиудын шууд хамтын ажиллагааг Эрасмус нэмэх хөтөлбөр /Erasmus plus Programme/-ийн хүрээнд явуулахыг эрмэлзэнэ.
- 1.6 Талууд Итали Улсын холбогдох дээд боловсролын сургалтын байгууллага, Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн их сургууль болон Соёл, урлагийн их сургуультай хоёр улсын хууль тогтоомжийн хүрээнд хамтарсан сургалтын хөтөлбөр боловсруулах чиглэлээр хамтран ажиллахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.7 Талууд монгол оюутныг итали хэлний сургалтад, мөн итали оюутныг монгол хэлний сургалтад суралцахыг хөхиүлэн дэмжинэ. Үүнд Итали болон Монгол Улсад дээд боловсрол эзэмших хүсэлтэй оюутнуудад зориулан хоёр улсад зохион байгуулагдах хэлний тусгай курс зэрэг арга хэмжээ багтаж болно.
- 1.8 Талууд тухайн санхүүгийн жилд олгогдсон төсөв санхүүгийн боломжид нийцүүлэн нөгөө улсын оюутнуудад тэтгэлэг олгоно. Жил бүр олгох сургалтын тэтгэлэгтэй холбогдох шийдвэрийг дипломат шугамаар харилцан мэдэгдэнэ.

### **Хэлний сургалт**

- 1.9 Талууд өөрсдийн хэл, соёлыг харилцан суралцах, түгээхийг дэмжинэ. Энэ нь аялал жуулчлалыг дэмжих хүрээнд ч мөн хамаарна.
- 1.10 Талууд өөрсдийн санхүүгийн бололцоонд тулгуурлан дипломат шугамаар хүсэлт тавьсан тохиолдолд боловсрол, соёлын байгууллагыг өөрсдийн хэлний ном, сурах бичгээр хангах, хэлний төвийн багш нарт зориулсан сургалт, лекц зохион байгуулах нөөц боломжийг судлан үзнэ.

## **2 ДУГААР ЗҮЙЛ**

### **СОЁЛ, УРЛАГ, СПОРТЫН САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА**

#### **Соёлын байгууллагын хамтын ажиллагаа**

- 2.1 Талууд өөрсдийн нутаг дэвсгэрт нөгөө улсын соёлын байгууллага болон түүний салбарыг байгуулах, хөгжүүлэх, үйл ажиллагаа явуулахыг нь дэмжинэ.
- 2.2 Талууд 1972 оны ЮНЕСКО-н “Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тунхаглал” болон 2003 оны “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай” конвенцын дагуу хамтран ажиллана. Түүнчлэн Талууд 2005 оны “Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай ЮНЕСКО-ийн конвенц”-ийн дагуу хамтран ажиллана.

## **Спорт болон залуус солилцоо**

- 2.3 Талуудын нутаг дэвсгэрт зохион байгуулагдаж буй олон улсын болон дэлхийн хэмжээний тэмцээнд өөрсдийн тамирчдын оролцоог ханган, Олимпын хороодоор дамжуулан олон төрөлт спортын хамтын ажиллагааг дэмжинэ. Талууд өөрсдийн орны залуус ба спортын байгууллага хоорондын харилцааг дэмжин ажиллахын зэрэгцээ хоёр улсад зохион байгуулагдах залуус, спортын арга хэмжээнд харилцан төлөөлөгч оролцуулахыг дэмжинэ.
- 2.4 Талууд спортын анагаах ухаан, бэлтгэл сургуулилт, спортын удирдлага менежментийн хүрээнд хамтран ажиллах, тодорхой төрлийн спортын дасгалжуулагч, тамирчид солилцох, хамтарсан бэлтгэл сургуулилт хийх, зэрэг допингийн эсрэг хамтын үйл ажиллагааг хөхиүлэн дэмжинэ. Талууд 2005 оны ЮНЕСКО-н Биеийн тамир спорт дахь допингийн эсрэг Олон Улсын Конвенцоор хүлээсэн үүрэг, амлалтын дагуу хамтран ажиллана.

## **Үзэсгэлэн**

- 2.5 Талууд түүх, соёлын өвийн болон урлагийн зэрэг харилцан сонирхож буй чиглэлээр өндөр зэрэглэлийн үзэсгэлэн харилцан солилцохыг дэмжинэ. Үзэсгэлэн солилцох тусгай нөхцөлийг талуудын эрх бүхий байгууллага хооронд гэрээ байгуулан тохиролцоно.

## **Хөгжим**

- 2.6 Талууд өөрийн нутаг дэвсгэрт нөгөө талын жүжигчид, уран бүтээлчид, томоохон хөгжмийн зохиолчдын тоглолтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ. Энэхүү зорилгын хүрээнд, талууд хоёр улсын томоохон хөгжмийн компани, мэргэжлийн өндөр чадавх бүхий байгууллага хоорондын хамтын ажиллагааг дэмжинэ.
- 2.7 Талууд Игалийн хөгжмийн дээд сургууль, филармонид Монголын сонгодог найрал хөгжмийн удирдаач нарыг сургахыг дэмжинэ.

## **Кино**

- 2.8 Талууд дотоодын хууль тогтоомжийн дагуу кино урлагийн салбарт үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн байгууллага, холбоо болон бусад хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн хамтын ажиллагааг дэмжинэ. Тухайлбал: Талууд дараах үйл ажиллагааг дэмжин ажиллана:
- а) Мэргэжлийн жүжигчин зэрэг кино урлагийн мэргэжилтэн солилцох;
  - б) Кино фестиваль, бага хурал, семинар зэрэг олон улсын киноны арга хэмжээнд харилцан төлөөлөгч оролцуулах.

### **Соёлын томоохон арга хэмжээ**

- 2.9 Талууд баяр наадам, ойн баяр болон бусад соёлын арга хэмжээний зохион байгуулалтын талаарх мэдээллийг харилцан солилцож мөн энэхүү үйл ажиллагаанд талуудын төлөөлөгчдийг оролцохыг дэмжинэ.
- 2.10 Талууд хоёр улсын дуурийн дуулаач, мэргэжлийн уран бүтээлчдийн фестиваль зохион байгуулахыг дэмжинэ.
- 2.11 Соёл урлагийн томоохон арга хэмжээний зохион байгуулалтын зардлыг хоёр улс холбогдох журамдаа нийцүүлэн эдийн засгийн болон санхүүгийн хамгийн хэмнэлттэй нөхцөлөөр тохиролцоно.
- 2.12 Санхүүгийн нөхцөлийн талаар тохиролцсон хоёр талт хэлэлцээр байхгүй тохиолдолд нөгөө талын уран бүтээлчид, аялан тоглогчдын оролцох соёл урлагийн томоохон арга хэмжээний зохион байгуулалтын зардлыг хариуцах сонирхол бүхий байгууллагатай хамтран ажиллана.
- 2.13 Италийн Соёлын яамнаас эдийн засгийн дэмжлэг хүссэн аливаа санал санаачилгыг хүлээн авахаас өмнө холбогдох зөвлөлдөх хорооноос эерэг үнэлгээ өгсөн байхыг шаардана.

### **Номын сан**

- 2.14 Талууд дотоодын хууль тогтоомжийн хүрээнд хоёр орны номын сангийн хамтын ажиллагааг дэмжих зорилгоор дараах дэмжлэгийг үзүүлнэ:
- а) ном, зохиол бүтээлийн солилцоо;
  - б) дипломат шугамаар хүсэлт гаргавал тус салбарын мэргэжилтнийг солилцоно.

Эдгээр санал санаачилгыг Италийн талаас хэрэгжүүлэх үүргийг Соёлын яамны харьяа Номын сан, соёлын байгууллагын ерөнхий газар хариуцна.

### **Утга зохиол ба хэвлэн нийтлэл**

- 2.15 Талууд хоёр улсын соёлын талаарх мэдлэгийг гүнзгийрүүлэхэд хувь нэмэр оруулах үүднээс сонгодог болон орчин үеийн ном, зохиолыг орчуулах, хэвлэхийг дэмжинэ. Энэ зорилгын хүрээнд Италийн тал дараах зүйлсийг мэдээлж байна. Үүнд:
- Италийн уран зохиол, шинжлэх ухааны бүтээлийн орчуулга, италийн бүрэн болон богино хэмжээний киноны хөрвүүлэг, тайлбар бичиг болон дуу оруулалтыг хийсэн италийн болон/эсхүл гадаадын нийтлэгч, орчуулагч нарт Итали Улсын Гадаад хэрэг, олон улсын хамтын ажиллагааны яам (Олон нийт, соёлын харилцааны ерөнхий газар)-аас олгодог шагнал, санхүүгийн тусламж зэрэг бөгөөд Санхүүгийн тусламж авах өргөдлийг дипломат шугамаар илгээнэ.

- Бүгд Найрамдах Итали Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Соёлын яамнаас холбогдох уран зохиолын болон шинжлэх ухааны бүтээлийг итали хэлнээс өөр хэлнээ орчуулсан эсхүл өөр хэлнээс итали хэлнээ орчуулсан гадаадын орчуулагч, редакторт олгодог “Орчуулгын үндэсний шагнал”.

### **Соёлын өвийг хадгалах, хамгаалах, сэргээн засварлах**

- 2.16 Талууд соёлын өвийн сэргээн засварлалт, археологи, музейн судалгаа, архитектур, байгалийн судалгааны салбарын мэдээлэл, хэвлэмэл материал, мэргэжлийн шинжээч солилцоог дэмжинэ. Мөн энэ хүрээнд хоёр тал орчин үеийн урлаг, архитектурын салбарын мэдлэг, туршлагаа харилцан солилцоно.
- 2.17 Талууд хоёр орны холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн Итали Улсад болон Монгол Улсад явуулж буй археологийн, удамшлын болон антропологийн үйл ажиллагааг дэмжинэ.
- 2.18 Талууд дотоодын хууль тогтоомжийн дагуу болон “Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай” 1970 оны ЮНЕСКО-н Конвенцоор хүлээсэн үүрэг, амлалтад нийцүүлэн хамтран ажиллана. Мөн “Хулгайлагдсан ба хууль бусаар хилээр гаргасан соёлын объектын тухай” 1995 оны ЮНИДРУА-ын конвенцын зарчмыг хүндэтгэнэ.
- 2.19 Талууд өөрсдийн нутаг дэвсгэрт хууль бусаар импортолсон соёлын объект, урлагийн бүтээлийг нөхөн сэргээх, үнэлэх, тэдгээрийг хууль ёсны өмчлөгчид нь буцаан олгоход хамтран ажиллана.

## **3 ДУГААР ЗҮЙЛ**

### **ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА**

- 3.1 Талууд шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааг дараах чиглэлээр үргэлжлүүлэн хөгжүүлнэ. Үүнд:
  - a) Эрүүл мэнд;
  - b) Эрчим хүч, ялангуяа сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах;
  - c) Хөрс судлал;
  - d) Палеонтологи ба Антропологи;
  - e) Биологи;
  - f) Археологи;
  - g) Геологи;
  - h) Хими;
  - i) Ботаник;
  - j) Экологи;
  - k) Соёлын өвийг хамгаалах технологи;
  - l) Арьс, шир боловсруулах, үйлдвэрлэх технологи;

- m) Ноос, ноолуур боловсруулах, үйлдвэрлэх технологи;
- n) Байгалийн гамшгийн хяналт шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэхэд хэрэглэдэг дэлхий судлалын технологи;

3.2 Талууд хоёр улсын их сургууль, төрийн болон хувийн хэвшлийн судалгааны төв, бусад байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлж, дараах үйл ажиллагааг дэмжинэ:

- a) Залуу судлаач нарыг сургах;
- b) Эрдэм шинжилгээ, судалгаа ажлын талаарх мэдээлэл харилцан солилцох;
- c) Эрдэмтдийг харилцан солилцох;
- d) Хоёр талын болон олон улсын хурал зохион байгуулах;
- e) Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг ашиглах бизнесийн санал санаачилга;
- f) Хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлэх.

#### **4 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

##### **РАДИО ТЕЛЕВИЗИЙН САЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА**

4.1 Талууд тус тусын сонирхсон байгууллагууд хоорондын хэлэлцээрийг дэмжих замаар радио телевизийн салбарын харилцан солилцоонд дэмжлэг үзүүлнэ.

#### **5 ДУГААР ЗҮЙЛ**

##### **ЗОХИОГЧИЙН ЭРХ**

5.1 Талууд зохиогчийн эрхийн салбарын холбогдох байгууллага хоорондын хоёр талт хамтын ажиллагааг дэмжинэ.

#### **6 ДУГААР ЗҮЙЛ**

##### **ЕРӨНХИЙ БОЛОН САНХҮҮГИЙН ЗААЛТУУД**

###### **6.1 Харилцан айлчлал**

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах хоёр талын харилцан айлчлалыг дараах байдлаар зохицуулна:

6.1.1 Илгээгч тал тус хөтөлбөрийн 1.4 дүгээр зүйлд заасан айлчлал хийх тухай айлчлал хийхээр товлосон өдрөөс гурван (3) сараас доошгүй хугацааны өмнө Хүлээн авагч

талд дипломат шугамаар мэдэгдэнэ. Илгээгч тал тус айлчлалтай холбогдуулан дор дурсан мэдээллүүдээр хангана:

- a) Зочны овог, нэр, паспортын мэдээлэл;
- b) Зочны товч намтарт ерөнхий мэдээлэл болон хэлний мэдлэгийн талаар мэдээллийг тусгасан байх;
- c) Зочны айлчлалын төлөвлөгөөнд хүлээн авах байгууллагын тухай мэдээлэл, оролцохоор товлосон арга хэмжээ, үйл ажиллагааны талаарх мэдээлэл;
- d) Айлчлалын эхлэх болон дуусах огнооны тухай мэдээлэл.

Тус айлчлалд Бүгд Найрамдах Итали Улсын талаас оролцогч нь Бүгд Найрамдах Итали Улсын, эсхүл Европын холбооны гишүүн орны иргэн байх, харин Монголын талаас оролцогч нь Монгол Улсын Иргэн байж болно.

- 6.1.2 Хүлээн авагч тал айлчлах хүсэлтийг хүлээн авсан тухайгаа тухай айлчлалыг хийхээр товлосон өдрөөс нэг (1) сараас доошгүй хугацааны өмнө Илгээгч талд дипломат шугамаар мэдэгдэнэ.
- 6.1.3 Илгээгч тал олон улсын ирэх, очих замын зардлыг хариуцна.
- 6.1.4 Хүлээн авагч тал нь өөрийн улсын нутаг дэвсгэрт зорчих унааны зардлыг бүрэн хариуцна.
- 6.1.5 Айлчлалд оролцсон хоёр орны их, дээд сургуулийн багш, судлаачид айлчлал дууссан өдрөөс хойш гуч (30) хоногийн дотор айлчлалын хүрээнд хийгдсэн ажлын талаарх эцсийн тайлангаа илгээгч талын холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.
- 6.1.6. Хүлээн авагч тал нөгөө Талын их, дээд сургуулийн багш, судлаач нарын 8 хүртэл хоногийн айлчлалын зам хоногийн зардлыг жил бүр олгоно.


## **6.2. Төгсгөлийн зүйл**

- 6.2.1 Энэхүү хөтөлбөрт тусгагдсан бүхий л санаачилгыг Талууд тухайн жилийн төсвийн боломж, олон улсын эрх зүйгээр хүлээсэн үүрэг, хариуцлагын хүрээнд, хоёр улсын дотоодын холбогдох хууль тогтоомжийн дагуу, Европын Холбооны гишүүн орны хувьд Итали Улсын хүлээх үүрэг, хариуцлагын хүрээнд хэрэгжүүлэхээр тохиролцов.
- 6.2.2 Талууд энэхүү хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд хүсэлтээ дипломат шугамаар дамжуулан илэрхийлэх бөгөөд хоёр улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авна.
- 6.2.3 Энэхүү хөтөлбөр нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд дараагийн хөтөлбөрт гарын үсэг зурах хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ. Хүчин төгөлдөр байх хугацаа 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс хэтрэхгүй.

6.2.4 Энэхүү хөтөлбөрийн хугацааг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид сунгаж болно.

Энэхүү хөтөлбөрийг 2022 оны 4 сарын 19 ний өдөр Ром хотноо итали, монгол болон англи хэлээр тус бүр 2 хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Хөтөлбөрийг тайлбарлахтай холбоотой зөрүү гарвал англи хэл дээрх эх бичвэрийг баримтална.

БҮГД НАЙРАМДАХ ИТАЛИ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ

